

Японы замын тэмдэг, тэмдэглэгээг мөрдөө (1)

	Явган зорчигч ч, тээврийн хэрэгсэл ч заавал зогсох ёстой. Баруун эргэх, зүүн эргэхийг хориглоно.		Энэ тэмдэглэгээтэй газар түр зогсох ёстой.
	Улаан гэрэл ассан ч, сумны чиглэлд нэвтрэх боломжтой.		
	Тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжгүй. * Тээврийн хэрэгсэл ч, дугуй ч хамааралтай.		Энэ тэмдэглэгээтэй газар хурдаа сааруулах ёстой. * 10км/ц-с бага, даруй зогсож чадах хурд.
	Хоёр дугуйтаас бусад тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжгүй.		
	Том оврын ачааны тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжгүй.		Тоогоор заасан хурднаас хэтрүүлж болохгүй.
	Автомашин зорчих зориулалттай зам тул, явган хүн, дугуй, мопед зэрэг нэвтрэх боломжгүй.		
	Явган хүн, дугуй зорчих зориулалттай зам тул, бусад тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжгүй.		Явган хүний гарц дээр явган зорчигч зорчих үед түр зогсож, зам тавьж өгөх ёстой.
	Явган хүний зам тул, тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжгүй.		

Японы замын тэмдэг, тэмдэглэгээг мөрдөө (2)

	Нэг урсгалын хөдөлгөөнд зөвхөн сумны чиглэлд явах ёстой.		Тээврийн хэрэгсэл зөвхөн сумны чиглэлд явах боломжтой.
	Энэ тэмдэглэгээтэй чиглэл рүү нэвтрэх боломжгүй.		Уулзвар дээр явах чиглэлийн дагуу зөв зураасаар явах ёстой.
	Эргэх хориотой.		
			Заасан тээврийн хэрэгсэлд зориулагдсан тусгай зураас юм.
	Өмнөх автомашиныг гүйцэд түрүүлэхдээ шар шугмаас баруун талд гарах хориотой.		
			Энэ замын цаана төмөр замын гарам байна.
	Машин тавих, зогсох хориотой.		Энэ замын ойролцоо сургуультай, хүүхдүүд байнга явдаг зам юм.
	Машин тавих хориотой.		Энэ замын цаана уулзвар байна.

Замын хөдөлгөөний дүрмийг баримталж, Японд аюулгүй жолоо баръя (1)

(1) Зүүн гар талын дүрэм



- ★ Япон улсад автомашин замын зүүн гар талаар зорчдог. Өмнө нь баруун гар талын замын хөдөлгөөнтэй улс оронд жолоо барьж байсан хүмүүс уулзвар дээр эргэх үедээ андуурч баруун талаар явах магадлалтай байдаг тул, анхааралтай зорчино уу.
- ★ Замын баруун талаар явах нь замын хөдөлгөөний дүрэм зөрчих, осол гаргах аюултай.

(2) Зам тээврийн осол гарсан бол, заавал цагдаад мэдэгдэнэ үү

- ★ Зам тээврийн осол гарсан бол, гэмтсэн хүнгүй байсан ч, заавал цагдаа (110) -д мэдэгдэнэ үү. Гэмтсэн хүн байвал, тэдэнд тусламж үзүүлж, түргэний машин (119) дуудаж, цагдаа (110) -д мэдэгдэнэ үү.
- ★ Гэмтсэн хүнд тусламж үзүүлээгүй, цагдаад мэдэгдээгүй тохиолдолд, хатуу шийтгэл ногдуулахын зэрэгцээ тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулах зэрэг захиргааны чанга арга хэмжээ ногдуулдаг.



(3) Согтуугаар жолоо барихыг хориглоно

- ★ Архи согтууруулах ундаа хэрэглэсэн бол жолоо барьж болохгүй. Хатуу шийтгэл ногдуулахын зэрэгцээ тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулах зэрэг захиргааны чанга арга хэмжээ ногдуулдаг.
- ★ Согтуурсан үедээ жолоо барих эрсдэлтэй хүнд жолоо бариулахыг хориглоно. Мөн жолоо барихыг шаардах эсвэл уриалж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүний машинд суухыг хориглоно. Эдгээр дүрмийг зөрчвөл хатуу шийтгэл ногдуулна.



Архи согтууруулах ундаа хэрэглэсний дараах өдөр архи гараагүй бол жолоо барьж болохгүй!

(4) Төмөр замын гарамд бүрэн зогсоно

- ★ Төмөр замын гарц дээр дохио дуугараагүй байсан ч бүрэн зогсож, галт тэрэгний дуу чимээг сонсож шалгасны дараа нэвтэрнэ



(5) Явган зорчигч нэгдүгээрт

- ★ Японд явган зорчигч нэгдүгээрт байдаг. Явган хүний гарц, уулзвар дээр явган зорчигч гарч байвал түр зогсож, зам тавьж өгөөрэй.



(7) Гар утас хэрэглэхийг хориглоно



- ★ Жолоо барьж байхдаа, онцгой байдлаас бусад тохиолдолд гар утас ашиглах, дэлгэц ширтэх нь хатуу хориотой.

(6) Уулзвар дээр онцгой анхаарна уу

- ★ Уулзвар дээр "(1) Явган зорчигч нэгдүгээрт", "(2) Баруун эргэх үед тууш замын машин түрүүлнэ"
- ★ Явган хүний гарамгаар хүн гарч байвал, эсвэл гатлах гэж байвал "түр зогсох" ёстой.



(8) Замын тэмдэгийн утгыг зөв ойлгох

Японд таны эх орноос өөр замын хөдөлгөөний дүрэм, замын тэмдгийг мөрдөнө.



Stop signs

- ★ Энэ тэмдэгтэй газарт заавал түр зогсож, зүүн баруун талын аюулгүй байдлыг шалгаарай.

Замын хөдөлгөөний дүрмийг баримталж, Японд аюулгүй жолоо баръя (2)

(9) Өөрийн жолоодож болох тээврийн хэрэгслийн ангиллыг мэдэх байх хэрэгтэй.

- ★ Таны эх орны жолооны үнэмлэхээр жолоодож болох тээврийн хэрэгслийн ангилалаас өөр байдаг.
- ★ Өөрийн жолоодож болох тээврийн хэрэгслийг шалгаж жолоодъё.

Ердийн тээврийн хэрэгсэл	Суудлын тоо 10 хүн хүртэл Нийт жин 3,500кг-с бага Ачааны жин 2,000кг-с бага	
Бага дунд оврын тээврийн хэрэгсэл	Суудлын тоо 10 хүн хүртэл Нийт жин 7,500кг-с бага Ачааны жин 4,500 кг-с бага	* Ачааны жин, суудлын тоог тээврийн хэрэгслийн бүтэцтэй гэрчилгээгээс шалгаж, ачаа тээвэрлэх боломжтой эсэхийг нягталсны дараа жолоодоорой.
Дунд оврын тээврийн хэрэгсэл	Суудлын тоо 29 хүн хүртэл Нийт жин 11,000 кг-с бага Ачааны жин 6,500 кг-с бага	
Том оврын тээврийн хэрэгсэл	Суудлын тоо 30 хүнээс дээш Нийт жин 11,000 кг-с дээш Ачааны жин 6,500 кг-с дээш	
Том моторт дугуй	Суудлын тоо 2 хүн хүртэл Хөдөлгүүрийн багтаамж 400сс эсвэл 20кВт-с дээш хүчин чадалтай	* Зарчмын хувьд жолооны үнэмлэх авснаас хойш 1 жил (хураны замд 3 жил) хөвүүлээс сундлагдаж болохгүй.
Ердийн моторт дугуй	Суудлын тоо 2 хүн хүртэл Хөдөлгүүрийн багтаамж 400сс эсвэл 20кВт-с бага хүчин чадалтай	
Чирүүлэх тээврийн хэрэгсэл	Нийт жин нь 750кг-с дээш чиргүүлийн тэрг	

★ Автобус, такси жолоодох тухай

- Автобус, такси (зорчигч тээврийн үйлчилгээ) жолоодохын тулд, тусдаа "хоёрдугаар зэрэглэлийн жолооны үнэмлэх" хэрэгтэй.
- Унадаг дугуйны төрлөөс хамааран "хоёрдугаар зэрэглэлийн жолооны үнэмлэх" авах хэрэгтэй.
- Мөн зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд, хоёрдугаар зэрэглэлийн жолооны үнэмлэхээс гадна Зам тээврийн газар зэрэг холбогдох байгууллагын зөвшөөрөл авах шаардлагатай.



(10) Ачих ачааны хэмжээ, ачих аргыг шалгаж

★ Зөвшөөрөл шаардлагатай ★

Урд хойно
Тээврийн хэрэгслийн кузовын нийт уртнаас 10-ны 1 хэсэг нь урд, хойд хэсгээс хэтэрсэн тохиолдолд

Зүүн баруун
Тээврийн хэрэгслийн кузовын нийт өргөнөөс 10-ны 1 хэсэг нь зүүн баруун хэсгээс хэтэрсэн тохиолдолд

Урт
Тээврийн хэрэгслийн уртдаг тухайн уртын 10-ны 2-г нэмж тооцсон хэмжээгээс хэтэрсэн тохиолдолд

Өргөн
Тээврийн хэрэгслийн өргөнд тухайн өргөний 10-ны 2-г нэмж тооцсон хэмжээгээс хэтэрсэн тохиолдолд

Өндөр
3.8 метр (хөнгөн оврын машин болон гурван дугуйт тээврийн хэрэгсэл бол 2.5 метр) -с тухайн тээврийн хэрэгслийн ачаа ачих хэсгийн өндрийг хассан хэмжээгээс өндөр байх тохиолдолд

- ★ Ачааны машинд ачаа ачих үед ачааны хэмжээ, ачилтанд хязгаарлалт байдаг.

- ★ Ачааг хувааж болохгүй тул, ачааны жин, хэмжээ, ачилтын хязгаарлалтаас хэтэрсэн тохиолдолд, ачаа тээвэрлэх жолооч нь хөдлөх газрынхаа харьяа цагдаагийн газрын даргын зөвшөөрөл авах шаардлагатай.



Жолооны үнэмлэхэд хүчинтэй хугацаа бий. Марталгүйгээр шинэчилнэ үү.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчих болон зам тээврийн осол гаргавал хатуу шийтгэл ногдуулдаг.